

## ТАНИЛЦУУЛГА

“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

### 1.Хүнсний ногоо үйлдвэрлэлийн талаар

Эрдэм шинжилгээний байгууллагаас хийсэн тариалангийн талбайн хөрсний төлөв байдлын шинжилгээгээр тариалангийн нийт талбайн 60 гаруй хувийн үржил шимиийн агууламж нь дундаас бага хэмжээнд хүрч элэгдэл, эвдрэлд орсон болохыг тогтоосон боловч өнөөг хүртэл дорвитой арга хэмжээ аваагүй байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн орлого муу, төрөөс үзүүлэх дэмжлэг хязгаарлагдмал тул хөрсийг бордох нөхөн сэргээх арга, талбайн хог ургамал хортон шавжтай технологийн дагуу тэмцэх арга хэмжээ авах боломжгүйгээс жил ирэх тутам ургацын хэмжээ буурч чанар муудаж байна.

Одоо байгаа техникийн хүчин чадлыг нийт ажлын хэмжээнд тооцож үзэхэд хүнсний ногооны механикуулалтын дундаж төвшин 40.0 хувьтай байна. Хүнсний ногоо тарих, арчлах, хураах, сортлох технологийн ажлуудын 60 гаруй хувийг гараар гүйцэтгэж, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх тал дээр бусад улсуудаас харьцангуй хоцрогдож байна.

### 2.Үр тариа, хүнсний ногооны үрийн талаар

Хүнсний ногооны гол нэр төрлийн ногооны үрээс шар лууван, шар манжин, хүрэн манжингийн үрийн ихэнх хувийг, байцааны үрийн 40 хувь, сонгины үрийн 5 хувь, сармисны үрийн 30 хувийг, ил талбайн хэмх, лоолийн 40 хувийг дотооддоо үйлдвэрлэж байна. Бага тархацтай ногоонуудын үрийг импортоор хангаж байна. Хүнсний ногооны үрийн хэрэгцээний тодорхой хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа хэдий ч бусад улсаас чанартай үрийг импортлох зайлшгүй хэрэгцээтэй байдаг.

Улсын хэмжээнд улаанбуудайн үр жилд 3 мянган тонны хэрэгцээтэй байдаг ч дотоодын /эрдэмж, шинжилгээний байгууллагын/ үйлдвэрлэлээр 300 тонн буюу 10 орчим хувийн хэрэгцээг хангаж, 90 хувийг импортоор авч байна. Тэжээлийн таримлын үрийг манай улс үйлдвэрлэхгүй байна.

Эдгээр шалтгаан, нөхцлөөс үүдэн техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, хөрсийг бордох, нөхөн сэргээх, талбайн хог ургамал хортон шавжтай технологийн дагуу тэмцэх арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийх нөхцлийг бүрдүүлэх зэргээр хүнсний ногоо, үр тарианы үйлдвэрлэлтэй холбоотой дотоодын зах зээлийг хамгаалах үндэслэл, шаардлага үүсэж байна гэж үзэж, уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор тогтоолын төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үе шатын дагуу хуулийн төслийг боловсруулав. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу тогтоолын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, тогтоолын төслийн үр нөлөөг үнэлсэн, тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах

зардлын тооцоог тус тус хийв. Уг судалгааны ажлуудын зөвлөмжид үндэслэн тогтоолын төсөлд холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан болно.

Тогтоолын төслийг Монгол Улсын олон услын гэрээ болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, дараах зохицуулалтыг тусгав. Үүнд:

1.Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-нд Төмс, Сонгино /сармис/, Байцаа, Шар лууван, Шар манжин тус бүр “20 хүртэл” гэсэн гаалийн албан татварын хувь хэмжээг, жил бүрийн 09 дүгээр сарын 01-ээс дараа оны 03 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд тус бүр “30” гэж өөрчлөлт оруулахтай холбоотой тогтоолын төслийн 1 дэх заалтыг Засгийн газраас санал авсны дараа иргэд, аж ахуйн нэгжээс удаа дараа гаргасан саналтай уялдуулан “жил бүрийн 09 дүгээр сарын 01-ээс дараа оны 03 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд” гэснийг хасаж, төслийн заалтыг өөрчилсөн;

2.Үр тариа, тэжээлийн таримал, төмс, хүнсний ногооны үрийн үйлдвэрлэл, үүссэн нэхцэл байдалтай уялдуулан гаалийн албан татварын хувь, хэмжээг “0” болгохтой холбоотой тогтоолын төслийн 2 дахь заалт;

3.Үр тариа, тэжээлийн таримал, хүнсний ногооны үрийн үндэсний кодод өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа тул үндэсний код батлахыг Засгийн газарт даалгасан тогтоолын төслийн 3 дахь заалт;

4.Тогтоолыг дагаж мөрдөх хугацааг заасан заалт.

## ХУУЛЬ САНААЧЛАГЧИД